



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 27

Номгон

**Төрийн захиргааны зарим албан хаагчдад  
зэрэг дэв олгох санал батлах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.8.2, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 9 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан хаагчдад төрийн алба хаасан болон тухайн албан тушаалд ажилласан хугацаа, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн зэрэг дэвийг шинээр болон ахиулж 8 дугаар сарын 01-ний өдрөөс тооцох саналыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн захиргааны албан хаагчдад шинээр болон ахиулан олгох зэрэг дэвийн саналыг УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч /Д.Сарангарав/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ